



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/161

Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны "Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай" А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх чиг үүрэг бүхий ажилтнуудад сургалт эрхлэн явуулах ашгийн төлөө бус хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч -(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: -(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)  
-(Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтэн)  
-(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: -(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

2. Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан ерөнхий шаардлага болон согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журамд заасан сургалт эрхлэн явуулах хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг хангасан төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж, сургалт явуулах хөтөлбөрийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэст үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ